

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дамдинсүрэнгийн Оюунсүрэн*

Abstract: This article examines the evolution of international legal regulation aimed at combating human trafficking from the early abolitionist movements to the contemporary global legal framework. It traces historical developments beginning with the 1807 British Abolition Act and early bilateral treaties to suppress the transatlantic slave trade, followed by the first multilateral instruments addressing the “white slave trade” in the early 20th century. The study highlights the major conventions adopted under the League of Nations, including the 1921 Convention for the Suppression of the Traffic in Women and Children and the 1926 Slavery Convention, which broadened the legal scope by defining slavery and prohibiting related practices. It further analyzes United Nations–era advances, such as the 1948 Universal Declaration of Human Rights, the 1949 Convention for the Suppression of the Traffic in Persons, subsequent conventions addressing forced labour and modern slavery-like practices, and specialized treaties protecting women and children. Particular emphasis is placed on the 2000 Palermo Protocol, which established the first comprehensive international definition of human trafficking and introduced a three-pillar approach: prevention, victim protection, and prosecution. The article also reviews policy trends, notable international initiatives, and good practices, as well as mechanisms for cooperation among states and non-state actors. Overall, the study underscores the progressive expansion and consolidation of international legal norms against human trafficking and the growing recognition of shared responsibility in addressing this transnational crime.

Keywords: Human trafficking, trafficking in persons, international legal regulation, modern slavery, Palermo Protocol, Prevention–protection–prosecution (3-P approach), transnational crime

Оршил

Хүний наймаа буюу хүн худалдаалах гэмт хэрэг нь хүн төрөлхтний түүхийн бүхий л үед оршиж ирсэн боолчлолын орчин үеийн хэлбэр бөгөөд даяаршлын улмаас эрчимжсэн улс хоорондын цагаачлал, дэлхийн эдийн засгийн тэгш бус байдал, их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөнөөс үүдэлтэй зэвсэгт мөргөлдөөн, дүрвэгсдийн хямрал зэрэг нь сая сая хүмүүсийг хүний наймааны золиос болоход хүргэсээр байна. Хэдийгээр хүний эрхийн суурь баримт бичгүүд, гэрээ конвенцод боолчлол болон боолын худалдаа, хүний наймааг таслан зогсоох, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хамгаалах зорилт тавьсаар ирсэн ч хүн худалдаалах явдал өнөөдөр ч олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдсан, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг хэвээр байна.

Хүн худалдаалахтай тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт нь XIX зууны эхэн үеийн боолчлолын эсрэг анхны хууль, цагаан арьстны боолын худалдааг хориглох хэлэлцээрүүдээс эхлэн, Үндэстнүүдийн Холбоо, улмаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд батлагдсан олон тооны гэрээ, конвенц, протоколыг дамжин хөгжсөөр иржээ. Эдгээр баримт бичиг нь хүний наймааны ойлголтын хүрээг өргөтгөж, хүний биеийг хүчээр үнэлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөг, боолчлолтой адилтгах заншил, хүүхдийн худалдаа зэрэг олон хэлбэрийг багтаахын зэрэгцээ урьдчилан

* МУИС-ийн УТСОУХНУС-ийн ахлах багш

Email: oyunsuren@num.edu.mn

ORCID: 0009-0000-3188-0088

сэргийлэх, хохирогчийг хамгаалах, гэмт хэрэгтнүүдийг мөрдөн шалгах, улс орнуудын хамтын ажиллагааг сайжруулах механизмыг агуулснаараа онцлог юм.

Энэхүү өгүүлэлд боолчлолын түүхэн ойлголт болон түүнийг устгах зорилготой олон улсын эрх зүйн анхны алхмуудаас өгсүүлээд НҮБ-ын хүрээнд батлагдсан гэрээ конвенцууд болон орчин үеийн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн тулгуур баримт бичиг болох Палермогийн протокол хүртэлх хөгжлийн чиг хандлагыг шинжлэхийг зорилоо. Мөн хүний наймаатай тэмцэхэд чиглэсэн олон улсын бодлогын шинэ чиглэлүүд, хохирогч хамгааллын арга механизм, улсуудын хамтын ажиллагааны сайн туршлагыг авч үзсэн болно.

Боолчлол ба цагаан арьстны боолчлол

Дэлхий дээр хүний наймаа боолын нийгмийн үеэс оршсоор ирсэн боловч илүү зохион байгуулалттай, өргөн цар хүрээг хамрах болсон нь Европын далайчид Америк тивийг нээж, олон тооны боолчуудыг Африк тивээс шинэ тив рүү зөөх болсон XVI зуунаас эхтэй юм. Европчууд 1680-аад онд нэг боолыг гурван фунт стерлингээр худалддаг байсан бол 1800 онд 30 фунт болж өсчээ. XVIII зуунд 10 сая гаруй африкчуудыг боол болгон худалдсан гэдэг тооцоо байдаг (BBC Bitesize, n.d.). 1807 онд Их Британид боолчлолын эсрэг анхны хууль батлагдах хүртэл боолын худалдааг хуулиар хориглодоггүй байсан төдийгүй тухайн үеийн олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрдөг байв. Хожим нь 1820 онд АНУ боолчлолыг хуулиар анх хориглосон түүхтэй. Тухайн үед бүх улс орныг эгнээндээ нэгтгэсэн олон улсын байгууллага байгаагүй учраас дэлхий нийтээр боолчлолыг хориглох боломжгүй байв. Тиймээс ч Их Британи улс Атлантын далай дахь боолын худалдааг зогсоохын тулд 31 улстай хоёр талын гэрээ байгуулах шаардлагатай болсон байдаг (Piotrowicz et al., 2017).

Хэдийгээр 1904 оны Цагаан арьст боолын худалдааг таслан зогсоох тухай олон улсын хэлэлцээрээс эхлээд *“хүний наймаа”* гэсэн ойлголтыг олон улсын эрх зүйн баримт бичигт дурдах болсон боловч нарийвчлан тодорхойлоогүй байдаг. *“Цагаан арьстны боолчлол”* гэх энэ нэр томъёог хар арьст африкчуудыг Америк, Европ руу боол болгон худалддаг практикаас ялгахын тулд хэрэглэх болсон. Уг ойлголтод голчлон цагаан арьст эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх, бэлгийн мөлжлөгт ашиглах явдлыг багтаадаг байв. 1904 оны Цагаан арьст боолын худалдааг таслан зогсоох тухай олон улсын хэлэлцээр нь эмэгтэйчүүд, охидыг *“цагаан арьст боолын худалдаа”* хэмээх эрүүгийн гэмт хэргээс хамгаалах зорилготой байв. Уг хэлэлцээрт хохирогчдын аюулгүй байдлыг хангах тухай дурдсан байдаг ч цагаач эмэгтэйчүүд, охидыг хянах, эх оронд нь буцаахад илүү анхаарсан.

1910 онд 13 улс Цагаан арьст боолын худалдааг таслан зогсоох тухай олон улсын конвенцод гарын үсэг зурав. Уг конвенцын гол онцлог нь хүн худалдаалах явдлыг гэмт хэрэгт тооцох асуудлыг хөндсөн. Тиймээс ч Европын олон оронд хүний наймааг таслан зогсоох үндэсний хороо байгуулагджээ. Гэвч Дэлхий н I дайн гарснаар тэдгээр байгууллагын үйл ажиллагаа тасалдахад хүрсэн. 1904 оны хэлэлцээр, 1910 оны конвенцын аль аль нь хүйс ба арьс өнгөөр ялгаварласан шинжтэй бөгөөд эрэгтэйчүүд болон, цагаан арьстнаас бусад эмэгтэйчүүд, охидод хамаардаггүй байсан нь учир дутагдалтай юм.

Үндэстнүүдийн Холбооноос баталсан боолчлол ба хүний наймааны эсрэг конвенцууд

Дэлхийн I дайны дараа 1919 онд Үндэстнүүдийн Холбоо байгуулагдсанаар дэлхий дахинаа тулгамдаж буй хүний наймааны асуудалд илүү анхаарал хандуулах болсон. Тиймээс ч 1921 онд Хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахыг таслан зогсоох тухай олон улсын конвенцыг баталсан бөгөөд *"цагаан арьстны боолчлол"* гэх нэр томъёог халж, *"эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах"* гэсэн нэр томъёог хэрэглэх болсон. Уг нэр томъёо нь хүн худалдаалах гэмт хэргийн хамрах хүрээг өргөжүүлж, зөвхөн цагаан арьст эмэгтэйчүүд, хүүхдүүд төдийгүй бусад бүх эмэгтэйчүүд, хүүхдийг хамруулснаараа ихээхэн ач холбогдолтой юм. Түүнчлэн эрэгтэй, эмэгтэй бүх хүүхдийг хамруулах болсон нь олон улсын хамтын нийгэмлэг анх удаа эрэгтэй хүүхдүүд ч гэсэн хүний наймааны золиос болж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болсон юм. Энэхүү конвенц нь Цагаан арьст боолын худалдааг таслан зогсоох тухай 1910 оны конвенцод дурдсан гэмт хэргийг багтааснаас гадна конвенцод эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг худалдаалж буй этгээдүүдэд ял шийтгэл оногдуулахад шаардлагатай арга хэмжээ авахыг улс орнуудад үүрэг болгосон байдаг.

Үндэстнүүдийн Холбооноос хүний наймаатай тэмцэх чиглэлээр гаргасан олон улсын эрх зүйн өөр нэг чухал баримт бичиг нь 1926 оны 9-р сарын 25-нд батлагдаж, 1927 оны 3-р сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон Боолын худалдаа, боолчлолыг хориглох тухай конвенц юм. Энэхүү конвенцод зааснаар *"боолчлол"* гэдэгт өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцлийг ойлгоно гэсэн. Мөн хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах, боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авах, худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах үйлдлийг *"боолын худалдаа"* хэмээн тодорхойлоод конвенцод нэгдэн орсон улсууд боолын худалдаа, боолчлолын эсрэг хатуу шийтгэл оногдуулах үүрэг хүлээсэн.

Үндэстнүүдийн Холбооны нэг агентлаг болох Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 1930 оны 6-р сарын 28-ны өдөр Албадан хөдөлмөрийн тухай 29-р конвенцыг баталсан нь хүний наймаатай тэмцэх бас нэгэн чухал алхам болжээ. Уг конвенцын 2-р зүйлд албадан хөдөлмөр гэдгийг *"ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж, аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээ"* хэмээн тодорхойлсон байна.

НҮБ-аас баталсан боолчлол ба хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүд

Дэлхийн II дайны дараа НҮБ байгуулагдсан нь дэлхий даяар боолчлолыг бүрмөсөн устгах, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн хөгжлийг шинэ шатанд гаргасан билээ. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 оны 12-р сарын 10-нд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг батлаж, дэлхийн бүх улс түмэн, бүх улс гүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзвэл зохих нийтлэг зорилт болгон дэвшүүлсэн. Тунхаглалын 3-р зүйлд *"Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй."*, 4-р зүйлд *"Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно."* (НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 1948) хэмээн заасан нь НҮБ-аас цаашид батлагдах хүний эрхийн холбогдолтой гэрээ конвенцын эрх зүйн үндэс болсон юм.

НҮБ 1949 онд [Хүн худалдаалах болон мөлжих зорилгоор бусдын биеийг үнэлүүлэхийг таслан зогсоох тухай конвенцыг](#) баталсан. Уг конвенц “*бусдыг биеийг нь үнэлүүлэх зорилгоор элсүүлсэн, уруу татсан, авч явсан этгээдийг хохирогчийн өөрийнх нь зөвшөөрөлтэй байсан ч, эсвэл бусдыг өөрийнх нь зөвшөөрөлтэй байсан ч биеийг нь үнэлүүлэн мөлжсөн этгээд*”-д хариуцлага хүлээлгэн, шийтгэж байх үүргийг оролцогч талуудад хүлээлгэсэн (OHCHR, n.d.). Ийнхүү хүн худалдаалах гэмт хэргийг биеэ үнэлэх явдалтай адилтган үзсэнээр биеэ үнэлэгч бүх эмэгтэйчүүдэд хохирогчийн статус олгосон. Нөгөө талаар, хүний наймаанд бус биеэ үнэлэх явдалд гол анхаарлаа төвлөрүүлсэн нь биеийг нь үнэлүүлэхээс бусад зорилгоор худалдаалсан хүмүүсийг хамгаалж чадахгүйд хүрсэн (Morcom & Schloenhardt, 2011) төдийгүй түүнийг хэрэгжүүлэх хяналт тавих механизм сул байв. Гэсэн хэдий ч НҮБ энэхүү конвенцыг баталснаар хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой өмнө батлагдаж байсан бүх олон улсын эрх зүйн баримт бичгийг нэгтгэж, уг гэмт хэрэгтэй тэмцэх шинэ эрх зүйн дэглэмийг бий болгосноороо ач холбогдолтой юм (Tosun, 2011).

НҮБ-ын Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц 1956 оны 9-р сарын 7-ны өдөр Женев хотноо батлагдсан бөгөөд 1957 оны 4-р сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Уг конвенцын 1-р зүйлд хараахан устаагүй байгаа дараах ёс болон заншлыг аль болох богино хугацаанд бүрэн халах буюу устгахын тулд шаардлагатай хуулийн болон бусад арга хэмжээг авах талаар дурдсан. Үүнд: Өрөөр барьцаалж боолчлох, хамжлага болгох, богтлож гэрлүүлэх болон хүүхдийг боолчлох. Түүнчлэн уг конвенцоор боолын худалдааг гэмт хэрэгт тооцох, нэгдэн орсон улсын далбаатай хөлөг онгоцонд орогнол эрсэн боолууд *ipso facto* эрх чөлөөтэй болох, бусдыг боолчлох буюу боол болгон өгөхийг гэмт хэрэгт тооцохоор болсон (НҮБ, 1956). Энэхүү Нэмэлт конвенц нь 1926 оны конвенцоос илүү өргөн цар хүрээг хамрах болсноороо ач холбогдолтой юм.

Түүнчлэн НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох ОУХБ-аас 1957 онд баталсан өөр нэг чухал баримт бичиг бол Албадан хөдөлмөрийг устгах тухай 105-р конвенц юм. Энэхүү конвенцод нэгдэн орсон улс орнууд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хориглосон. Гэвч бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгтэй харьцуулахад албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн талаар харьцангуй бага мэдээлдэг бөгөөд хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогчдыг цагаач ажилчдаас ялгахад хэцүү байдаг.

Дээр дурдсан хүний наймаатай холбоотой гэрээ конвенцууд нь хүн худалдаалах гэмт хэргийг голчлон хүний эрхийн зөрчил гэж авч үзсэн байдаг бол орчин үеийн хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг олон улсын эрх зүйн гол баримт бичиг болох НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 сарын 15-ны өдөр баталсан Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол нь мөн өдөр батлагдсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт протокол болон батлагдсанаараа онцлог юм. Ийнхүү хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хүний эрхээс олон улсын эрүүгийн эрх зүйд шилжүүлэн авч үзэх болсон нь 1990-ээд онд улс орнууд цагаачдыг хууль бусаар нэвтрүүлэх, худалдаалах явдлыг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болон уламжлалт бус аюул заналтай холбон авч үзэх болсонтой холбоотой. Тиймээс ч 1990-ээд оны сүүлээр НҮБ-ын Протоколын хэлэлцээрийг эхлүүлэхэд түлхэц өгсөн хүний эрхийн үүднээс бус харин улс орны аюулгүй байдал, бүрэн эрхт байдлын асуудал байв (Gallagher, 2010).

Палермогийн протокол хэмээн нэрлэгддэг Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай энэхүү протоколын 3-р зүйлд “хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ гэж заасан.

“Мөлжих” гэдэгт наад зах нь бусдын биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгож байна. Дээр дурдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүний наймааны хохирогч өөрийг нь мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэрэгсэхгүй. Мөн дээр дурдсан аргуудыг хэрэглээгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг “хүн худалдаалах” гэж үзнэ. Хүүхэд гэдэгт 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ гэсэн нь насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд гэмт хэрэг үйлдэхэд ашигласан арга огт хамааралгүй гэдгийг тодорхойлсон хэрэг юм.

Оролцогч улсууд хүний наймаанаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх зорилгоор судалгаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн кампанит ажил явуулах, түүнчлэн нийгэм, эдийн засгийн холбогдох санаачилгуудыг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авахыг эрмэлзэх ба ийнхүү тодорхойлсон бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээ нь зохих нөхцөлд ТББ-ууд, бусад холбогдох байгууллага болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран ажиллах асуудлыг хамарна. Мөн хүн худалдаалах гэмт хэрэгт хүргэж буй, хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг бүх хэлбэрээр мөлжих явдлыг бий болгодог эрэлт хэрэгцээний эсрэг чиглэсэн хууль тогтоох буюу боловсрол, нийгэм, соёлын гэсэн бусад арга хэмжээнүүдийг авах буюу боловсронгуй болгох үүргийг тус баримт бичгээр оролцогч улс орнуудад хүлээлгэжээ.

НҮБ-аас баталсан олон улсын эрх зүйн бусад баримт бичгүүд

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12-р сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9-р сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Оролцогч улсууд эмэгтэйчүүдийг худалдах, тэдний биеийг үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээг авах үүрэг хүлээсэн. Мөн эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийн салбарт эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгахын тулд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш эрхээр хангах зорилгоор зохистой бүх арга хэмжээг авах тухай заажээ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 оны 11-р сарын 20-нд баталснаас хойш 193 орон нэгдэн орсон бөгөөд хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн олон улс орон баталсан хүний эрхийн хэлэлцээр болсон юм. Хүүхдийн эрхийн конвенцын оролцогч улсууд хүүхдийг хууль бусаар шилжүүлэх буюу гадаад улсаас эх оронд нь буцаахгүй байхтай тэмцэх, эцэг

эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй. Мөн оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээсэн бөгөөд хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр хулгайлах, худалдах буюу хил дамжуулан худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэг хүлээсэн.

Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протоколыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 оны 5-р сарын 25-нд батлаж, 2002 оны 1-р сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Энэхүү протоколд зааснаар оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахыг хориглосон. Оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах, бэлгийн дур хүслээ хүүхдээр хангах аялал зэрэг үйл ажиллагаанд оролцсон этгээдийг таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн байцаах, эрүүгийн хэрэгт шалгах болон шийтгэх зорилгоор олон талт, бүс нутгийн болон хоёр талт тохиролцоо байгуулах замаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах үүрэг хүлээсэн. Мөн хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах, хүүхэд ашиглах секс аялалд нөлөөлж буй ядуурал болон хөгжлийн дорой байдал зэрэг шалтгааныг арилгах зорилгоор олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн. Эл зорилгоор олон талт, бүс нутгийн, хоёр талт болон бусад хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн, техникийн болон бусад туслалцааг зохих боломжийн хэрээр үзүүлэх тухай заажээ.

Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц 1993 оны 5-р сарын 29-ний өдөр батлагдаж, 1995 оны 5-р сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү Конвенц нь улс хооронд хүүхэд үрчлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхол болон түүний үндсэн эрх олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгаа бүрдүүлэх, хүүхэд хулгайлах, худалдах, хил дамнан худалдахаас сэргийлж тэдгээр баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсууд хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох, оролцогч улсууд Конвенцын дагуу хүүхэд үрчлэхийг зөвшөөрөх явдлыг хангуулах гол зорилготой.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182-р конвенц 1999 оны 6-р сарын 17-ны өдөр батлагдаж, 2000 оны 11-р сарын 19-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Конвенцод *“хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр”* гэдэгт *“боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах..., хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох...”* зэргийг ойлгоно гэж заасан. Уг конвенцын дагуу улс бүр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг нэн тэргүүнд устгахад чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

1998 оны 7-р сарын 18-нд батлагдаж, 2002 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийн 7-р зүйлд “Энгийн аливаа хүмүүст өргөн хүрээтэй буюу системтэйгээр, санаатай үйлдэж байгаа “боолчлох; хүчиндэх, бэлгийн боолчлолд оруулах, биеэ үнэлэхэд тулган хавчих, албадан жирэмслүүлэх, хүчээр засаж хөнгөлөх буюу адилтган үзэж болох бусад хүнд хэлбэрийн бэлгийн аливаа хүчирхийллийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг” гэж үзэх тухай заажээ.

Хүний наймаатай тэмцэж буй олон улсын чиг хандлага

Хүний наймаа, орчин үеийн боолчлол гэх зэргээр нэрлэгддэг хүн худалдаалах гэмт хэрэгт нийгмийн эмзэг бүлэг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд хамгийн ихээр өртдөг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэрэг төдийгүй хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж, нийгэмд асар их сөрөг үр дагавар авчирдаг. НҮБ Тогтвортой хөгжлийн зорилтуудыг баталснаар улс орнууд 2030 он гэхэд хүний наймааг таслан зогсоох үүрэг хүлээсэн боловч энэ төрлийн гэмт хэрэг дэлхийн өнцөг булан бүрт үйлдэгдсээр байна. Гэвч чухам хэдэн хүн уг гэмт хэргийн золиос болж байгаа талаар нарийвчилсан тоо баримт байдаггүй бөгөөд улс орнууд, олон улсын байгууллагууд харилцан адилгүй тоо баримт дурддаг. Тухайлбал, АНУ-ын Төрийн департаментын 2024 оны Хүний наймааны тайланд дэлхий даяар 27 сая хохирогч бүртгэгдсэн гэж дурдсан бол ОУХБ-ын 2022 оны тооцоогоор орчин үеийн боолчлолд 50 сая хүн өртөөд байна. Тэдний 27.6 сая нь албадан хөдөлмөрийн золиос болж байгаагийн 39.4% нь эмэгтэйчүүд, охид байна. (International Labour Organization, 2022).

Харин Франц улсын Гадаад ба Европын хэргийн яам жил бүр дэлхий даяар 2.5 сая гаруй хүн, түүний дотор дийлэнх хувь нь эмэгтэйчүүд, хүүхдүүд хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж байна гэж мэдэгдсэн (Ministère de l’Europe et des Affaires étrangères, n.d.).

Хүн худалдаалах гэмт хэрэг нь бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр, гэр бүлийн боолчлол, эрхтний наймаа, албадан гуйлга гуйлгах зэрэг олон арга хэлбэрээр үйлдэгддэг ч нийтлэг нэг чухал элементтэй байдаг нь хохирогчдыг мөлжиж, орлого олдог бизнес юм. Ашиг их олдог ч эрсдэл бага байдаг учраас зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн анхаарлыг татдаг. Тиймээс ч зэвсэг, хар тамхи, тамхины наймаанаас хүний наймаа руу шилжсэн гэмт бүлэглэл олон байдаг. НҮБ, Европын зөвлөлийн тооцоогоор гэмт хэрэгтнүүд хүний наймаанаас жилд 32 тэрбум гаруй долларын орлого олдог байна. Түүнчлэн, хүний наймаа нь Европ дахь хамгийн их ашиг орлоготой хууль бус бизнесийн нэг бөгөөд гэмт хэрэгтнүүд зөвхөн бэлгийн мөлжлөгөөс жилд 2.5 тэрбум еврогийн орлого олдог гэсэн мэдээлэл байдаг. ОУХБ-ын тооцоогоор хувийн хэвшил дэх албадан хөдөлмөрөөс дэлхийн хэмжээнд жилд 150 тэрбум долларын хууль бус ашиг олдог бөгөөд үүний 51.8 тэрбум доллар нь зөвхөн Ази, Номхон далайн бүс нутагт ногддог (Jovanovic, 2018).

Сүүлийн жилүүдэд хүн худалдаалах гэмт хэрэг бүртгэгдсэн улс орны тоонд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй ч нэг улсаас бүртгэгдэх хэргийн тоо тогтвортой өсөж байна. Энэ нь хүн худалдаалах хэргийн тохиолдол нэмэгдсэн гэхээс илүүтэй улс орнуудын хэрэг илрүүлэх, бүртгэх, мэдээлэх дотоод чадавхид ахиц гарч буйтай холбоотой юм. Ялангуяа дээрх нөхцөл байдал Ази

болон Америк тивийн улс орнуудад илүү ажиглагджээ (UNODC, 2018). Илрүүлэлт ерөнхий түвшиндээ сайжирч байгаа нь хүний наймаатай холбоотой мэдээллийг цуглуулах, тайлагнах чиглэлээр улс орнууд харилцан уялдаатай хамтран ажиллаж, нэгдсэн нэг стандартыг мэдээлэл цуглуулалтанд мөрдөж буйтай холбоотой гэж үзэж байна. Тухайлбал, 2009 онд 26 улсад хүний наймааны чиглэлээр дата, мэдээллийг цуглуулж, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий тусгай байгууллага байсан бол энэ тоо 2018 онд 65 болж өсчээ. Хүний наймааны кейс, тохиолдлын бүртгэл мэдээлэл сайжирснаар хүний наймаатай тэмцэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглүүлэх боломж олон талаар бүрдэж байна. Тухайлбал, бүх цаг үед хүний наймааны гэмт хэрэгтнүүд охид, эмэгтэйчүүдийг өөрсдийн бай болгосоор ирсэн боловч сүүлийн жилүүдийн олон улсын статистикийг харвал Төв Азийн улс орнуудад насанд хүрсэн эрэгтэй хохирогчдын хувь бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр болсон байна.

Хүний наймаанаас урьдчилан сэргийлэх бодлогын орчин, түүний хэрэгжилт

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр оролцогч улсууд (a) хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх; (b) хүн худалдаалах хэргийн хохирогчид, ялангуяа эмэгтэйчүүд ба хүүхдүүдийг дахин хэлмэгдэхээс хамгаалах зэрэг асуудлаар бүрэн цогц бодлого, хөтөлбөрүүд болон бусад арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

Одоогийн байдлаар яг хэдэн улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан талаар нэгдсэн тоо баримт алга байна. НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас гаргасан гарын авлагад Албани, Армени, Австрали, Бразил зэрэг 22 орны үндэсний хөтөлбөрийн талаар товч дурдсан. Олон улсын шилжилт хөдөлгөөний бодлогын хөгжлийн төв 2006 онд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний цогц хөтөлбөр хэрхэн боловсруулах талаар удирдамж (International Centre for Migration Policy Development, 2006) гаргасан бөгөөд улс орнууд үндэсний хөтөлбөрөө боловсруулахад ашиглах боломжтой юм. Монгол Улсын хувьд 2012 онд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан хууль, тус хуулийн хэрэгжилтийг хангах “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан 2017-2021 онд хэрэгжүүлсэн нь хүний наймаатай тэмцэх үндэсний эрх зүйн орчныг бүрдүүлж, олон улсын жишигт нийцүүлэх чухал алхам болсон (IRIM, 2022).

Хүний наймаанд өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг эмзэг байдлын хүчин зүйлд ядуурал, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг хүний эрхийн зөрчил багтдаг. Мөн биеэ үнэлэх, гэрийн үйлчлэгч хийх гэх мэт тодорхой төрлийн ажил эрхлэлт нь хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй байдаг. Тиймээс хүний наймаанаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эдгээр эмзэг байдлын хүчин зүйлсийг бууруулахад илүү анхаарал хандуулдаг.

Орон нутгийн олон нийтийн оролцоотой үйл ажиллагаа урьдчилан сэргийлэх чухал арга хэрэгсэл юм. Энэ чиглэлээр НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар олон төсөл хөтөлбөрийг дэмжин ажилладаг. Тухайлбал, 2006-2007 онд Энэтхэг-Балбын хил дээрх тосгоны олон мянган

оршин суугчдыг хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулсан Олон нийтийн сонор сэрэмжийг дээшлүүлэх төслийг санхүүжүүлсэн. Түүнчлэн Босни Герцеговин, Хорватын ТББ-уудад, ялангуяа эмзэг бүлэгт орогнол хүссэн хүмүүсийн дунд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх кампанит ажлыг зохион байгуулахад санхүүжилт олгож байжээ.

Сүүлийн жилүүдэд авлигыг бууруулах нь хүний наймаатай тэмцэх нэг чухал арга хэрэгсэл мөн болохыг хүлээн зөвшөөрөх болсон. Авлига бол хүний наймааг тайлбарлах хамгийн чухал хүчин зүйл бөгөөд албан тушаалын авлигын түвшин хамгийн өндөр улс орнууд хүний наймаатай тэмцэхэд хамгийн бага хүчин чармайлт гаргадаг. Тиймээс ч ЭЗХАХБ "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой авлигатай тэмцэх зарчмууд"-ыг боловсруулсан. 2015 оны 8-р сард уг зарчмуудыг практикт хэрэглэх туршилтыг Филиппин, Тайланд улсад амжилттай явуулсан бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой авлигатай тэмцэхэд чухал ач холбогдолтой болох нь харагдсан (OECD, 2016).

Хүний наймааны хохирогч хамгаалал, үйлчилгээтэй холбоотой бодлогын орчин, түүний хэрэгжилт

Палермогийн протоколоор оролцогч улсууд хүн худалдаалах хэргийн хохирогчдыг зохих ёсоор хамгаалах болон туслах үүрэг хүлээсэн. Хэдийгээр хохирогчдыг хамгаалах нь төрийн үүрэг боловч (a) зохих орон байраар хангах; (b) хүн худалдаалах хэргийн хохирогчдод ойлгогдох хэлээр, ялангуяа хуулиар тогтоосон эрхийн талаар зөвлөгөө ба мэдээлэл өгөх; (c) эмнэлгийн, сэтгэл зүйн ба материаллаг тусалцаа үзүүлэх; (d) хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон суралцах бололцоогоор хангах зэрэг арга хэмжээг засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллагууд болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран хэрэгжүүлж болно заасан.

Хүний наймааны хохирогч хамгаалал, үйлчилгээтэй холбоотой анхаарал татдаг гол зүйл бол хохирогчийг хэрхэн тодорхойлох вэ гэдэг асуудал юм. Олон улс орон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тодорхойлоход хайхрамжгүй ханддаг. Үүнээс үүдээд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүмүүс хохирогч гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүйн улмаас авах ёстой хамгаалалтаа авч чадахгүй байх тохиолдол олон бөгөөд ихэнхдээ хууль бус цагаач, хүн худалдаалагчдын хамтрагчид хэмээн шийтгүүлэх буюу тухайн улсаас албадан гаргагдахад хүрдэг. Зарим улсын засгийн газар хүний наймааг цагаачлалын хууль буюу үндэсний аюулгүй байдлыг зөрчсөн хэрэг гэж үздэг тул хүний наймаатай тэмцэх арга хэмжээндээ хохирогч хамгааллын асуудлыг эн тэргүүнд тавих сонирхол бага байдаг.¹ Тухайлбал, нөхөн олговор авах зэрэг хохирогчийн зарим эрхийг АСЕАН-ийн гишүүн олон орны дотоодын хууль тогтоомжид тусгаагүй байдаг. Малайз улсын хуулийн дагуу хохирогчид нөхөн олговор өгдөггүй, Мьянмар улсад гэмт хэрэгтнийг шүүгээгүй буюу гэм буруутайг нь тогтоогоогүй бол, эсвэл хураан авсан эд хөрөнгийг борлуулснаас олсон орлого байхгүй бол хохирогчид нөхөн төлбөр олгодоггүй. Хэдийгээр АСЕАН-ын гишүүн дийлэнх улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ямар нэгэн үндэсний сан байгуулсан (засгийн

газраас эсвэл хууль бус орлогыг хураах замаар санхүүждэг) боловч дотоодын хууль тогтоомжид уг сангаас хохирогчдод нөхөн төлбөр олгох боломжтой эсэх нь тодорхойгүй байна (Piotrowicz et al. 2017).

2010 оны 7-р сард НҮБ-ын Ерөнхий ассемблей Хүн худалдаалахтай тэмцэх Глобал үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Энэхүү төлөвлөгөөнд хүний наймааны гэмт хэргийн шинжийг тусгасны зэрэгцээ хүний эрхэд суурилсан, хохирогч төвтэй хандлагыг илүүтэй багтаасан. Тухайлбал, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслах сайн дурын сан байгуулсан нь зарим талаар орхигдоод байсан хохирогч хамгааллын ач холбогдлыг өргөж өгсөн. Уг төлөвлөгөө нь холбогдох бүх оролцогч талуудад авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зааж өгснөөс гадна тэдгээрийн хоорондын хамтын ажиллагаа, харилцан уялдааг сайжруулахад чиглэгдсэнээрээ ихээхэн ач холбогдолтой юм (Makei, 2013).

Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа

Палермогийн протоколоор оролцогч улсууд хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн гэмт хэрэгт тооцоход шаардлагатай бүх хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах үүрэг хүлээсэн.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчдэд зохих шийтгэл оногдуулж, хохирогчдод шударга ёсыг тогтооход үр дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа маш чухал үүрэгтэй. Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, үйлдлийг нь таслан зогсоох, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг шууд аюулаас зайлуулж, болзошгүй мөлжлөг, хор уршгийг арилгахад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь чухал ач холбогдолтой. Олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн томоохон бүлэглэлүүд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчид байдаг. Тиймээс ч ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд тусгай нөөц, ур чадвар шаарддаг учраас хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг.

Энэтхэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний наймаачдыг шүүхэд татах, хүний наймаанаас олсон хууль бус хөрөнгийг хураах, тэднээр хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэгт анхаардаг. Шинэ Зеландад хүн худалдаалах гэмт хэрэгт 20 жил хүртэлх хорих ялаар шийтгэж, 500,000 шинэ зеланд долларын торгууль ногдуулдаг. Вьетнам улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, буруутай этгээдэд ял шийтгэл онооход илүү анхаардаг боловч мөрдөн шалгах болон хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчдод дэмжлэг үзүүлэх, нөхөн олговор олгох талаар хангалттай анхаарал тавьдаггүй (Winterdyk et al., 2020).

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар улс орнуудын эрүүгийн шүүхийн тогтолцоог бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Энэ нь хүн худалдаалах гэмт хэргийг хуулиар эрүүгийн гэмт хэрэг гэж тооцохоос гадна тэрхүү хуулийг дагаж мөрдөх ёстой гэсэн үг юм. Тиймээс тус газар олон улс оронд холбогдох хууль тогтоомжийг боловсруулахад туслалцаа үзүүлсэн. Тухайлбал, 2006 онд Армени, Ливан, Өмнөд Африкт хүний наймааны эсрэг хууль тогтоомж боловсруулахад нь туслалцаа үзүүлсэн. Түүнчлэн Афганистан, Буркина Фасо, Финлянд, Гана, Лаос, Молдав, Нигери, Өмнөд Африк, Украин, Вьетнам зэрэг олон орны цагдаа, хилийн цэрэг, прокурор, шүүгч, ТББ-ын

ажилтнуудад сургалт явуулсан. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо өссөн (UNODC, n.d).

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээрх талуудын хамтын ажиллагаа

Палермогийн протоколын 9-р зүйлд “Оролцогч улсууд хүн худалдаалахад хүргэж буй, хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхдүүдийг бүх хэлбэрээр мөлжлэх явдлыг бий болгодог эрэлт хэрэгцээний эсрэг чиглэсэн хууль тогтоох буюу боловсрол, нийгэм, соёлын гэсэн бусад арга хэмжээнүүдийг, тухайлбал, хоёр буюу олон талаар хамтран ажиллах замаар авах буюу боловсронгуй болгох болно.”, 10-р зүйлд “...оролцогч улсуудын хууль сахиулах, цагаачлалын буюу бусад холбогдох байгууллагууд дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу зохих тохиолдолд нэг нэгэнтэйгээ мэдээлэл харилцан солилцох замаар хамтран ажиллана” гэж заасан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээрх талуудын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс болдог.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай, ихэвчлэн үндэстэн дамнасан шинжтэй байдаг учраас түүний эсрэг нэг улс, нэг байгууллага дангаар тэмцэхэд хүчин мөхөстнө. Тиймээс ч хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хамтын ажиллагааны сүлжээ илүү хүчтэй байх тусам эрүүгийн сүлжээ тэр чинээгээр сулрана. Энэ чиглэлээр Европын Зөвлөл ба АСЕАН-ын гишүүн орнууд үр дүнтэй хамтын ажиллагаа өрнүүлж байгаа сайн жишээ байна.

Европын Зөвлөл нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн дэвшилтэт бүс нутгийн хууль эрх зүйн орчныг бий болгосон. 2008 оны 2-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцыг "Европын Зөвлөлийн 60 жилийн түүхэн дэх хамгийн чухал ололт амжилтуудын нэг" гэж үздэг. Уг конвенцын дагуу байгуулагдсан Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг шинжээчдийн бүлэг (GRETA) нь гишүүн орнуудын хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг хянах үүрэгтэй бөгөөд "хамгийн чухал хяналтын механизм" гэж тооцогддог (Jovanovic, 2018).

Ази тивийн улс орнуудын хувьд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо бусад бүс нутагтай харьцуулахад илүү олон тул тус бүс нутгийн, тэр дундаа Зүүн Азийн улс орнуудын засгийн газрууд энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд ихээхэн хүч чармайлт гарган ажилладаг. 2004 онд Хятад, Тайланд, Камбож, Вьетнам, Лаос, Мьянмар улс Хүн худалдаалахтай тэмцэх ажлыг зохицуулах Меконгийн сайд нарын санаачилга (COMMIT) хэмээх өндөр түвшний бодлогын хэлэлцүүлгийг эхлүүлсэн. Энэ нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах болон тэднийг эх оронд нь буцаах, нийгэмшүүлэх, гэмт хэрэгтнүүдийг яллахад чиглэсэн хүчин чармайлтыг нэгтгэн хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нэгдсэн, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх бүтэц юм. COMMIT нь иргэний нийгмийн байгууллагууд болон залуучуудыг бүс нутгийн бодлого боловсруулахад оролцуулдаг (International Organization for Migration, n.d.). 2004 оны 10-р сард Их Меконгийн бүс нутагт хүний наймааны эсрэг хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан. Уг санамж бичигт нэгдсэн засгийн газрууд хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрийн эсрэг тэмцэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх бүрэн эрх бүхий үндэсний хэмжээний, салбар дундын хороо байгуулах, бүс нутгийн хамтын

ажиллагаа, мэдээлэл солилцоог бэхжүүлэх механизм бий болгох, үндэсний зохицуулагчийг томилох зэрэг үүрэг амлалт авсан (International Labour Organization, 2004).

2015 оны 11-р сард АСЕАН-ы Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц баталсан бөгөөд уг конвенцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан АСЕАН-ны Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Уг конвенцын удиртгал хэсэгт талууд хохирогчийг хамгаалах, ингэхдээ “хүний эрхийг нь бүрэн хүндэтгэх” үүрэг хүлээнэ гэдгээ дурдсан. Мөн хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалах гэмт хэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, гэмт хэрэг үйлдэгчдэд шударга бөгөөд үр дүнтэй шийтгэл оногдуулах, эдгээр зорилтыг биелүүлэхийн тулд талуудын хамтын ажиллагааг дэмжих үүрэг хүлээсэн. Гэсэн хэдий ч хохирогч хамгааллын тухайд уг конвенцын заалт Европын зөвлөлийн конвенцтой харьцуулахад учир дутагдалтай юм (Jovanovic, 2018).

“Хүн худалдаалах, цагаачдыг хууль бусаар хил нэвтрүүлэхтэй тэмцэх глобал үйл ажиллагаа - Ази ба Ойрх Дорнод” (GLO.ACT Ази ба Ойрх Дорнод) нь 2018-2022 онд НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Европын Холбоо, ОУШХБ-тай хамтран Афганистан, Иран, Ирак, Ирак, Пакистан зэрэг 4 улсад хэрэгжүүлж буй 12 сая еврогийн санхүүжилттэй төсөл юм. Энэхүү төсөл нь үр дүнтэй стратеги, бодлого боловсруулах, хууль тогтоомжийг олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр засгийн газрын болон иргэний нийгмийн байгууллагуудад тусалцаа үзүүлдэг.

Дүгнэлт

Хүний наймаа, орчин үеийн боолчлол гэх зэргээр нэрлэгддэг хүн худалдаалах гэмт хэрэгт нийгмийн эмзэг бүлэг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд хамгийн ихээр өртдөг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэрэг төдийгүй хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж, нийгэмд асар их сөрөг үр дагавар авчирдаг.

Хүний наймааны эсрэг олон улсын эрх зүйн тогтолцоо нь XIX зууны боолчлолыг хориглосон анхны гэрээ конвенцоос эхлээд бүх хэлбэрийн мөлжлөгийг хамарсан өнөөгийн иж бүрэн зохицуулалт хүртэлх урт хугацаанд хөгжиж иржээ. Хүн худалдаалах гэмт хэрэг нь түүхийн туршид олон хэлбэрээр илэрч байсан төдийгүй улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжил, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан улам бүр нарийн зохион байгуулалттай, хил дамнасан гэмт хэрэг болж өргөжжээ.

19–20-р зуунд боолчлолыг хориглох анхны оролдлого, цагаан арьст боолын худалдааны эсрэг гэрээ конвенцууд нь тодорхой бүлэгт чиглэсэн, хязгаарлагдмал хүрээнд үйлчилдэг байсан бол Үндэстнүүдийн Холбоо болон хожим НҮБ байгуулагдсанаар энэ ойлголтыг илүү өргөн хүрээнд авч үзэх болж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, бүх насны хүүхэд, мөн хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн бүхий л хэлбэрийг хамруулах болжээ.

НҮБ-аас 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд боолчлолын бүх хэлбэрийг хориглосон нь Хүн худалдаалах болон мөлжих зорилгоор бусдын биеийг үнэлүүлэхийг таслан зогсоох тухай конвенц, Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц зэрэг хүний эрхийн холбогдолтой гэрээ конвенцын эрх зүйн үндэс болсон юм. Гэхдээ эдгээр конвенц голчлон бусдын биеийг үнэлүүлэх зорилготой хүний наймаанд төвлөрч, мөлжлөгийн бусад хэлбэрийг орхигдуулсан нь хязгаарлагдмал байв. Тиймээс 2000 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (Палермогийн протокол) хүн худалдаалах гэмт хэргийг анх удаа иж бүрэн, тодорхой, өргөн хүрээтэйгээр тодорхойлж, “урьдчилан сэргийлэх – хохирогчийг хамгаалах – гэмт хэрэгтэй тэмцэх” гэсэн гурван тулгуур зарчмаар олон улсын стандартыг тогтоосон юм.

Ингэснээр XXI зуунд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн орчин илүү уялдаа холбоотой, хариуцлага тооцох чадвартай, хохирогч төвтэй тогтолцоонд шилжсэн гэж үзэж болно. Гэсэн ч даяаршил, зэвсэгт мөргөлдөөн, ядуурал, хөдөлмөрийн зах зээлийн тэгш бус байдал зэрэг суурь шалтгаанууд хэвээр байгаа тул энэхүү гэмт хэрэг бүр мөсөн устах болоогүй байна. Тиймээс улс орнуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, мөн эрэлт бий болгох хүчин зүйлсийг бууруулах бодлогын арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх шаардлага өнөөдөр ч хэвээр байгаа билээ.

НОМ ЗҮЙ:

Монгол хэлээр:

1. IRIM (2022). *Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа: Судалгааны тайлан*. Улаанбаатар: International Organization for Migration (IOM).
2. Монгол Улсын Засгийн газар (2017), *Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр* <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207908>
3. НҮБ-ын Ерөнхий Ассамблей. (1948). *Хүний эрхийн түгээмэл тунхаглал*. Монгол Улсын олон улсын гэрээ. <https://legalinfo.mn/mn/detail/1271>
4. НҮБ (1956). *Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц*. <https://legalinfo.mn/mn/detail/1291>

Англи хэлээр:

1. BBC Bitesize. (n.d.). Implications of the slave trade for African societies. BBC. <https://www.bbc.co.uk/bitesize/guides/zxt3gk7/revision/2>
2. Gallagher AT. Frontmatter. In: *The International Law of Human Trafficking*. Cambridge University Press; 2010
3. International Labour Organization. (2024). *Forced labour, modern slavery and trafficking in persons*. ILO. <https://www.ilo.org/global/topics/forced-labour/lang--en/index.htm>
4. International Organization for Migration. (n.d.). *Coordinated Mekong Ministerial Initiative against Trafficking (COMMIT) process*. IOM. <https://www.iom.int/coordinated-mekong-ministerial-initiative-against-trafficking-commit-process>

5. International Labour Organization. (2004, October 29). COMMIT memorandum of understanding on cooperation against trafficking in persons in the Greater Mekong Sub-region. ILO. <https://www.ilo.org/resource/commit-memorandum-understanding-cooperation-against-trafficking-persons>
- Jovanovic, M. (2018). *Comparison of anti-trafficking legal regimes and actions in the Council of Europe and ASEAN: Realities, frameworks and possibilities for collaboration* (Council of Europe). <https://rm.coe.int/coe-asean-study-thb/16808c1b91>
6. International Centre for Migration Policy Development. (2006) *Guidelines for the Development and Implementation of a Comprehensive National Anti-Trafficking Response*. <https://www.icmpd.org/publications?country=&topic=45386&contentType=&author=&authorId=&page=7>
7. Makei, V. (2013) *Human trafficking in the post-Cold War period: Towards a comprehensive approach*. Journal of International Affairs. <https://jia.sipa.columbia.edu/news/human-trafficking-post-cold-war-period-towards-comprehensive-approach>
8. Morcom, C., & Schloenhardt, A. (2011). All about sex?! The evolution of trafficking in persons in international law (Research paper). University of Queensland, TC Beirne School of Law. <https://law.uq.edu.au/files/4311/Evolution-of-Int-Law-relating-to-Trafficking-in-Persons.pdf>
9. OECD (2016), *Trafficking in Persons and Corruption: Breaking the Chain*, OECD Public Governance Reviews, OECD Publishing, Paris. <http://dx.doi.org/10.1787/9789264253728-en>
10. Office of the United Nations High Commissioner for Human Rights. (n.d.). Traffic in persons. OHCHR. <https://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/TrafficInPersons.aspx>
11. Office of the United Nations High Commissioner for Human Rights. (n.d.). *Supplementary Convention on the Abolition of Slavery, the Slave Trade and Institutions and Practices Similar to Slavery*. OHCHR. <https://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/SupplementaryConventionAbolitionOfSlavery.aspx>
12. Piotrowicz, R., Rijken, C., & Uhl, B. (Eds.). (2017). *Routledge Handbook of Human Trafficking* (1st ed.). Routledge. <https://doi.org/10.4324/9781315709352>
13. United Nations Office on Drugs and Crime. (2018). *Global report on trafficking in persons 2018*. https://www.unodc.org/documents/data-and-analysis/glotip/2018/GLOTiP_2018_BOOK_web_small.pdf
14. Winterdyk, J., & Jones, J. M. (Eds.). (2020). *The Palgrave international handbook of human trafficking*. Palgrave Macmillan.

Франц хэлээр:

1. Ministère de l'Europe et des Affaires étrangères. (n.d.). Lutte contre la traite des êtres humains. Diplomatie.gouv.fr. <https://www.diplomatie.gouv.fr/fr/politique-etrangere-de-la-france/droits-de-l-homme/lutte-contre-la-traite-des-etres-humains/fr>
2. Tosun, L. (2011). *La traite des êtres humains: étude normative* [Thèse de doctorat, Université de Grenoble]. <https://tel.archives-ouvertes.fr/tel-00634880/document>